



**НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН
ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ**

2018 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 132


Улаанбаатар хот

**“Улаанбаатар хотын аварга шалгаруулах”
“Уулын дугуй”-н нээлттэй тэмцээнийг
зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 144 дүгээр зарлиг, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын аварга шалгаруулах “Уулын дугуй”-н нээлттэй тэмцээнийг 2018 оны 04 дүгээр сарын 21-22-ны өдөр Хүйн долоон худагт зохион байгуулсугай.
2. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, шүүгчдийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 1.500.000 /нэг сая таван зуун мянган/ төгрөгийг Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны уралдаан тэмцээний зардлаас гаргахыг нягтлан бодогч /О.Эрдэнэцэцэг/-д зөвшөөрсүгэй.
4. Тэмцээний урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг Спортын хөгжлийн хэлтэс /С.Саранцэцэг/-т үүрэг болгосугай.


ДАРГА



Ж.ГАНБОЛД

1150500078


Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооны
даргын 2018 оны...*04 дугуй*... сарын *17*-ны өдрийн
А/ба дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Улаанбаатар хотын аварга шалгаруулах
Уулын дугуйн тэмцээний төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн /төг/
1.	Тамирчдын шагнал: 8 x 20.000 төг = 160.000 төг 8 x 15.000 төг = 120.000 төг 10 x 10.000 төг = 80.000 төг	360.000
2.	Багийн шагнал	200.000
3.	Шүүгчдийн ажлын зардал: /15 хүн x 2 өдөр x 20.000 төг/	600.000
4.	Өргөмжлөл	50.000
5.	Медаль:	240.000
6.	Анонс	50.000
Нийт дүн		1.500.000

Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооны
даргын 2018 оны 04 дугаар сарын 17-ны өдрийн
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Улаанбаатар хотын аварга шалгаруулах
“Уулын дугуй”-н нээлттэй тэмцээний
шүүгчдийн бүрэлдэхүүн

- | | |
|-----------------------|---------------|
| 1. Ерөнхий шүүгч | З.Наран |
| 2. Нарийн бичиг шүүгч | А.Алдар |
| 3. Шүүгч | С.Отгонбаатар |
| 4. Шүүгч | Б.Батсайхан |
| 5. Шүүгч | С.Сайнхүү |
| 6. Шүүгч | А.Алтангэрэл |
| 7. Шүүгч | Б.Баясгалан |
| 8. Шүүгч | Э.Мөнхтулга |